



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 494

Улаанбаатар хот

Жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1, 20 дугаар зүйлийн 20.4, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2 дахь хэсэг, Тагнуулын ерөнхий газрын 2025 оны ТЕГ01/521 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Санхүүгийн зохицуулах хорооны албаны нууцад хамаарах баримт бичиг, мэдээллийн жагсаалт”-ыг баталсан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 304 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтад өөрчлөлт оруулж, хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Батлагдсан жагсаалтыг нууц баримт бичгийг боловсруулах, хадгалж хамгаалах, ашиглах үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 304 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



1518001126

Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2025 оны 12 дугаар сарын 31 ны өдрийн
494 дугаар гушаалын хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ БАРИМТ БИЧИГ,
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Албаны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл
1	Албаны нууцад хамаарах мэдээллээр төрийн байгууллага, бусад этгээдтэй харилцсан албан бичиг, мэдээлэл
2	Албаны нууцад хамаарах мэдээлэл хэлэлцсэн хуралдааны тэмдэглэл, шийдвэр, бусад нууц тээгч
3	Албаны нууцад хамаарах мэдээллийг агуулсан дотоод аудитын ажлын тайлан, холбогдох баримт бичиг
4	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
5	Албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, бусад тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан, устгасан тухай мэдээ, акт, баримт бичиг
6	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээ, мэдээлэл
7	Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэл

----- ооо -----